



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 12 өдөр

Дугаар А/66

Чингис хот

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалт, Улсын Онцгой комиссын 2020 оны 04 дүгээр хурлын тэмдэглэл, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/19 тоот албан даалгавар, Аймгийн онцгой комиссын 2020 оны 02 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын болон аймгийн Онцгой комиссоос гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, Шинэ төрлийн коронавирусийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, зорилгоор холбогдох байгууллагуудыг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах, иргэд олон нийтэд мэдээлэл хүргэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:	Ж.Ганбаатар	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
Нарийн бичгийн дарга:	Б.Бат-Эрдэнэ	Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, ахлах дэслэгч
Гишүүд:	Н.Хүрэлээ	Цэргийн штабын дарга, хурандаа
	Д.Баасандорж	Эрүүл мэндийн газрын Халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн
	К.Кульжан	Нэгдсэн эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга
	Г.Наранхүү	Зооноз өвчин судлалын төвийн дарга
	Н.Мөнхчимэг	Мэргэжлийн хяналтын улсын хяналтын ахлах байцаагч
	Д.Амаржаргал	Нийтийн хэв журмыг хамгаалах тасгийн дарга, цагдаагийн ахмад
Э.Батхүрэл	Тагнуулын хэлтсийн ахлах ажилтан, ахмад	
С.Наранхүү	Авто тээврийн улсын байцаагч	

231010190

2.

Г.Болд

Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын дарга

Ө.Одмаа

“Өндөрхаан” телевизийн захирал

Д.Мөнхбаатар

“Бүргэд” телевизийн захирал

Д. Одонтунгалаг

Хэнтий мэдээ агентлаг

2. Аймгийн хэмжээнд иргэдэд үйлчилдэг албан байгууллага, аж ахуйн нэгж, банк, худалдаа үйлдвэрлэл, үйлчилгээний газруудад амьсгалын замын коронавирус /coronavirus/-ын халдвараас урьдчилан сэргийлэх талаар гарсан шийдвэрийн хэрэгжилт, зохион байгуулсан ажилд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг ажлын хэсэг /Ж.Ганбаатар/-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Г.Хэрлэнчулуун/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА